БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

2026 оны ........ дүгээр сарын ...........

# "НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

"НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Б.МӨНХБАТ

Улаанбаатар хот 2026 он

## АГУУЛГА


НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ ..... 2

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ ..... 2

2.1 Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг ..... 2

2.2. Хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд хамаарах Мандатын шижилгээ ..... 3

2.3. Салбар хоорондын болон харилцагч байгууллагуудын оролцоо ..... 5

2.4. Томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хууль, эрх зүйн судалгаа ..... 5

ГУРАВ. АЛСЫН ХАРАА ..... 6

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО ..... 6

ТАВ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ҮНЭТ ЗҮЙЛС ..... 6

ЗУРГАА. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ ..... 7

6.1. Байгууллагын дотоод орчны шинжилгээ /SWOT/ ..... 7

6.2. Байгууллагын Гадаад орчны шинжилгээ /PEST/ ..... 8

6.3. Хэлтсүүдийн гадаад, дотоод орчны шинжилгээ /SWOT/ ..... 9

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ ..... 12

НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ ..... 13

8.1. Стратегийн зорилго, бүтцийн уялдаа ..... 13

8.2. Стратегийн зорилго, бодлогын баримт бичгийн уялдаа ..... 15

8.3. Стратегийн зураглал ..... 16

ЕС. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 17

АРАВ. ХАВСРАЛТ ..... 23

Хавсралт 1. Хууль, эрх зүйн мэдээлэл ..... 23

Хавсралт 2. Хөрөнгө оруулалтын ажлын мэдээлэл ..... 26

Хавсралт 3. Байгууллагын өнөөгийн байдал ..... 28

Хавсралт 4. Стратегийн зорилгын уялдаа, зураглал ..... 36

Хавсралт 5. 2025-2028 оны зардлын төлөвлөгөөний төсөөлөл ..... 38

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Аливаа байгууллагын ажилчдын идэвх, санаачлага, бүтээлч байдал, чин эрмэлзлийг дэмжиж, хөгжлийн төлөөх тэдний оролцоог нэгтгэн зангидах замаар хөгжлийн бодлого, төлөвлөгөө биеллээ олж байдаг. Байгууллагын ажилчдын хөгжлийн төлөөх оролцооны нэг хэлбэр бол тэдний оролцоотойгоор байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх явдал мөн. Иймд "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, стратегийн үндэслэл, алсын хараа, эрхэм зорилго, стратегийн болон үйл ажиллагааны зорилт гарах үр дүн, хэрэгжүүлэх арга механизмыг байгууллагын стратеги төлөвлөгөөгөөр тодорхойлсон.

**Үндсэн зарчим.** "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын 2024-2028 он хүртэлх үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад дараах зарчмуудыг баримталсан болно. Үүнд:

- Байгууллагын хүний нөөц, чадавхын давуу талд тулгуурлахын зэрэгцээ, сул тал, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх асуудлыг төлөвлөгөөнд тусгагдсан аль ч асуудлын хувьд харгалзан үзэх,
- Ажилтан ажиллагсдын бүтээмжийг нэмэгдүүлэх замаар байгууллагын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх,
- Гадаад хүчин зүйлсийн боломжийг зөв ашиглах.

**Боловсруулсан аргачлал:**

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна" хэмээн заасан. Үүний дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 100 дугаар тушаалаар шинэчлэгдсэн "Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал"-д нийцүүлэн стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэх шаардлага үүсч байгаа юм. Үүнтэй уялдуулан, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор баталсан "Нийслэлийг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", 2025 оны 24/08 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг шинээр боловсруулж байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын засаглалын төлөв байдлын үнэлгээний зөвлөмжийг стратегийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлийг ажиллах чиглэлийн дагуу боловсруулалт хийж ажилласан болно.

## ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

### 2.1 Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг

**"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын чиг үүрэг, зохион байгуулалт**

Манай газар нь улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан болон бусад хөрөнгөөр нийслэлд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлдэг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар юм.

2010 онд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 49 дүгээр тогтоолоор "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 25/92 дугаар тогтоолоор "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан.

**Үйлдвэрийн газрын дүрмээр хүлээсэн үйл ажиллагааны зорилго, үндсэн чиг үүрэг:**

Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн зорилго нь Захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх, чанар, үр дүнг дээшлүүлэх замаар шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэхэд оршино.

Үйлдвэрийн газар нь үйл ажиллагааны дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын хөрөнгө орулалт, зээл тусламжийн болон бусад хөрөнгө оруулалтаар хэрэгжиж төсөл арга хэмжээнд гэрээний үндсэн дээр гүйцэтгэлийн хяналт тавих;
- ✓ хөрөнгө оруулалтын судалгаа шинжилгээний үр дүнгийн саналаа холбогдох газар хүргүүлэх, хамтран ажиллах;
- ✓ зураг төслийг хянах, түүний хэрэгжилтийн ажлыг зохион байгуулах, зураг төсвийн ажилд гэрээний үндсэн дээр хяналт тавих;
- ✓ захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулах, төсөл арга хэмжээний техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн бичиг баримтын бүрдлийг хянаж, захиалагчид хүргүүлэн батлуулах;
- ✓ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ил далд ажлын актыг баталгаажуулах, материалын стандартыг хангуулах, шаардлага тавих;
- ✓ эрх шилжсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт тавих, бүртгэх тайлагнах, үр ашгийг нэмэгдүүлэх санал боловсруулан хэрэгжүүлэх;
- ✓ төсөл, арга хэмжээний хүрээнд шинэ техник технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх;
- ✓ хууль тогтоомжоор хориглоогүй бусад.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/666 дугаар тушаалаар "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар шинэчлэн батлах тухай захирамжийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

*Хүснэгт 2.1 – 1. Газрын бүтэц, орон тоо*

| № | Хэлтэс | Орон тоо |
|---|---|---|
| 1 | Удирдлага | 3 |
| 2 | Хууль, дотоод хяналтын хэлтэс | 8 |
| 3 | Захиргааны хэлтэс | 14 |
| 4 | Санхүү, аж ахуйн хэлтэс | 17 |
| 5 | Барилга захиалагчийн хяналтын хэлтэс | 40 |
| 6 | Зураг төслийн хяналтын хэлтэс | 8 |
| 7 | Төлөвлөлт судалгааны хэлтэс | 12 |
| 8 | Мэдээллийн технологийн хэлтэс | 6 |
| | **Нийт** | **108** |

## 2.2. Хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд хамаарах Мандатын шижилгээ

*Хүснэгт 2.2 – 1. Мандатын шинжилгээ*

| Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо | | 31 |
|---|---|---|
| Үүнээс: | Тухайн салбарын хуулиуд | 3 |
| | Нийтлэг мөрддөг хуулиуд | 28 |
| **Ерөнхий чиг үүрэг-1: Захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх, чанар, үр дүнг дээшлүүлэх** | | |
| **Үндсэн чиг үүрэг** | **Дэд чиг үүрэг** | **Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид** |

| | | |
|---|---|---|
| ҮЧҮ-1: Улс, Нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын хөрөнгө орулалт, зээл тусламжийн болон бусад хөрөнгө оруулалтаар хэрэгжиж төсөл арга хэмжээнд гэрээний үндсэн дээр гүйцэтгэлийн хяналт тавих | Барилга байгууламж болон инженерийн шугам сүлжээ, их засварын ажлуудын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх;<br><br>Батлагдсан ажлын зураг төсөлтэй барилга байгууламжийн ажилд зохиогчийн хяналтын гэрээг байгуулж, хяналт хийлгэх | Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харъяа газар агентлагууд, Гүйцэтгэгч компаниуд |
| ҮЧҮ-2: Хөрөнгө оруулалтын судалгаа шинжилгээний үр дүнгийн саналаа холбогдох газар хүргүүлэх, хамтран ажиллах | Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг судлан, дүн шинжилгээ хийж үр дүнгийн саналаа холбогдох газруудад хүргүүлэх, хамтран ажиллах;<br>Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагатай төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулах; | Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харъяа газар агентлагууд, Дүүргүүд |
| ҮЧҮ-3: Зураг төслийг хянах, түүний хэрэгжилтийн ажлыг зохион байгуулах, зураг төсвийн ажилд гэрээний үндсэн дээр хяналт тавих | Барилга байгууламжийн зураг төсөлд тавигдах шаардлагыг хангуулах, зураг төслийг үе шатны дагуу боловсруулах, зөвшилцөх, батлах, магадлал хийхтэй холбоотой үйл ажиллагаанд захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх;<br>Зураг төслийн ажлын гэрээт хугацаанд төлөвлөлт, холбогдох хууль, норм ба дүрэм, журам, стандартын дагуу гүйцэтгүүлж, төлөвлөгөөт хугацаандаа хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэхэд хяналт тавих; | Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харъяа газар агентлагууд, Гүйцэтгэгч компаниуд |
| ҮЧҮ-4: Захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулах, төсөл арга хэмжээний техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн бичиг баримтын бүрдлийг хянаж, захиалагчид хүргүүлэн батлуулах | Барилга байгууламж болон их засварын ажлын техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн баримт бичгийг хянаж шилжүүлэх;<br><br>Төсөл, арга хэмжээний барилга угсралтын болон зураг төслийн ажлын гүйцэтгэлийг чиг үүргийн хүрээнд хянах; | Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харъяа газар агентлагууд, Гүйцэтгэгч компаниуд |
| ҮЧҮ-5: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ил далд ажлын актыг баталгаажуулах, материалын стандартыг хангуулах, шаардлага тавих | Барилгын үйл ажиллагаанд холбогдох норм, нормативын баримт бичгийг баримтлан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг хангах арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагаар хангуулах шаардлага тавих;<br>Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг дүрэм журмын дагуу зохион байгуулахад оролцох;<br>Дууссан барилга байгууламжийг Нийслэлийн өмчид бүртгүүлэх, архивын нэгж болгон архивд хүлээлгэх өгөх; | Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харъяа газар агентлагууд, Гүйцэтгэгч компаниуд |
| ҮЧҮ-6: Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт тавих, бүртгэх тайлагнах, үр ашгийг нэмэгдүүлэх санал боловсруулан хэрэгжүүлэх | Газарт хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын нийгэм, эдийн засгийн үр ашгийн дүн шинжилгээ хийх, хэтийн хөрөнгө оруулалтын боловсруулах, тайлан бэлтгэх;<br>Газарт захиалагчийн хяналт тавин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний мэдээ, мэдээллийг бүх үзүүлэлтээр гаргаж удирдлагуудад танилцуулах, холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллах; | Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харъяа газар агентлагууд, Гүйцэтгэгч компаниуд |

| | | |
|---|---|---|
| | Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтийн биелэлт гаргах | |
| ҮЧҮ-7: Төсөл, арга хэмжээний хүрээнд шинэ техник технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх | Барилга байгууламж болон инженерийн шугам сүлжээ, их засварын ажлуудын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх; | Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харьяа газар агентлагууд, Гүйцэтгэгч компаниуд |
| ҮЧҮ-8: Хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагааг эрхэлж болно. | Хүчин төгөлдөр мөрдөж буй норм норматив, стандартууд болон бусад холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн нийгэм эдийн засгийн зорилт, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн холбогдох заалт, нийслэлийн урт, дунд, богино хугацааны хөтөлбөрын хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаанд батлагдсан журмын хүрээнд хяналт тавьж газрын даргыг мэдээллээр хангах, хэрэгжилт хангалтгүй байгаа ажлуудыг эрчимжүүлэх талаар санал зөвлөмж өгөх; | Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харьяа газар агентлагууд, Гүйцэтгэгч компаниуд |

### 2.3. Салбар хоорондын болон харилцагч байгууллагуудын оролцоо

Салбар хоорондын болон харилцагч байгууллагдыг тодорхойлохдоо үндсэн чиглэл, үйл ажиллагааны хүрээнд харилцаж буй бусад байгууллагуудын чиглэл, эрх хэмжээг үндэслэсэн болно. Үүнийг ерөнхий байдлаар нь авч үзвэл:

- ✓ **Дээшээ чиглэлд харьцах байгууллага:** Салбарын хүрээний Дээд шатны байгууллага, албан тушаалтны гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангаж ажиллах, ажлын үр дүнг тайлагнаж ажиллах
- ✓ **Хэвтээ чиглэлд харьцах байнууллага:** Салбарын болон үйл ажиллагааны хүрээнд үйл ажиллагаагаа уялдуулах, хамтран ажиллах
- ✓ **Доошоо чиглэлд харьцах байгууллага:** Үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж буй байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээ, мэдээлэл авч ажиллах

### 2.4. Томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хууль, эрх зүйн судалгаа

"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ нь төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй барилга угсралт, их засвар, зураг төсвийн ажилд захиалагчийн хяналтыг мэргэжилийн түвшинд тавьдаг үндсэн чиг үүрэгтэй байгууллага бөгөөд Нийслэлд гадаадын зээл тусламж болон төсвийн хөрөнгөөр хэрэгжих томоохон мега төсөл, хөтөлбөрүүдэд захиалагчийн хяналтыг тавих боломжтой бүх чиглэлийн инженер техникийн ажилтан, албан хаагчтай байгууллага юм. "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан бодлогын хүрээний 12 төсөл, арга хэмжээнээс дараах төсөл, хөтөлбөрүүдэд захиалагчийн хяналтыг тавих боломжтой гэж үзэж байна. Үүнд:

1. Толгойтоос Амгалан хүртэл Энхтайваны өргөн чөлөө дагуу 17.7 км урт Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл **"Метро" төслийн бүтээн байгуулалтын** ажлыг эхлүүлнэ.
2. Буянт-Ухаа спорт цогцолбороос 120 мянгантын уулзвар, Сүхбаатарын талбай хүртэл 13.1 км урттай болон Ард Аюушийн өргөн чөлөө, Их тойруу Нямъянжүгийн гудамж, Нийслэл хүрээ өргөн чөлөө дагуу 11.9 км урттай **"Тусгай замын аютобус" /BRT/ төслийн бүтээн байгуулалтын** ажлыг эхлүүлнэ.
3. Зүнжин худалдааны төвөөс Сүхбаатарын талбай хүртэл 20.4 км урт **"Улаанбаатар хөнгөн галт тэрэг" төслийн бүтээн байгуулалтын** ажлыг эхлүүлнэ.
4. **"Шинэ тойрог зам",** "Туулын хурдны авто зам" барих төслийг эхлүүлнэ.

Дээрх томоохон 4 мега төслүүдийн барилга угсралт, инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлуудын техник хяналтыг чиг үүргийнхээ хүрээнд хэрэгжүүлэх бүрэн боломжтой бөгөөд авто зам, замын байгууламжийн ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх боломжийг судлан ажиллаж байна. Авто зам, замын байгууламжийн техникийн хяналттай холбоотой дараах хууль, эрх зүйн баримт бичиг байна. Үүнд:

**Хууль:**

- ✓ Авто замын тухай хууль:
  - ➢ Авто зам, замын байгууламжийг төлөвлөх, барих, засварлах, ашиглах, захиалагчийн чиг үүрэг, хяналтын зохицуулалтыг хийх
- ✓ Барилгын тухай хууль:
  - ➢ Барилгын үйл ажиллагаа, захиалагч, гүйцэтгэгч, хяналтын чиг үүрэгтэй оролцох;
  - ➢ Барилгын ажилд тавих техникийн болон зохиогчийн хяналт чиг үүрэгтэй оролцох;
- ✓ Хот байгуулалтын тухай хууль:
  - ➢ Хотын дэд бүтэц, авто замыг хот байгуулалтын баримт бичигтэй уялдуулан ажиллах.

**Засгийн газрын тогтоол, салбарын журам:**

- ✓ Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник, технологийн хяналт хэрэгжүүлэх журам:
  - ➢ Захиалагчийн хяналт тавих үүрэгтэй оролцох.
- ✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах журам:
  - ➢ Зам, гүүрийг хүлээн авах, комиссын бүрэлдэхүүн, шалгуур үзүүлэлтийн дагуу ажиллах.

**Салбарын норм, стандарт, дүрэм:**

- ✓ Барилгын норм ба дүрэм (БНбД)
  - ➢ Авто зам, гүүр, хоолой, замын байгууламжийн техникийн шаардлагын дагуу ажиллах

**Нийслэлийн удирдлагын эрх зүйн баримт бичиг:**

- ✓ Нийслэлийн Засаг даргын захирамж
  - ➢ Авто замын барилга, засварын захиалагчийн чиг үүргийн эрх шилжүүлэх

Дээрх хууль, эрх зүйн баримт бичигтэй уялдуулан авто зам, замын байгууламжийн техник хяналтыг хэрэгжүүлэх бүрэн боломжтой бөгөөд хүний нөөцийн өөрчлөлтийн удирдлагыг хэрэгжүүлэх замаар инженер техникийн ажилчдын дотоод нөөц бололцоог нэмэгдүүлэн ажиллах боломжтой юм.

## ГУРАВ. АЛСЫН ХАРАА

*"ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИНД ЭЭЛТЭЙ, ЧАНАРЫГ ЭРХЭМЛЭСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ЦОГЦЛООНО"*

## ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

*"ОЛОН УЛСЫН ТҮВШИНД НИЙЦСЭН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛНЭ"*

## ТАВ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ҮНЭТ ЗҮЙЛС

### 5.1 Баримтлах зарчим:

- ✓ хууль дээдлэх;
- ✓ үнэнч шударга байх;
- ✓ хүнлэг, энэрэнгүй байх;
- ✓ захирах, захирагдах ёсыг баримтлах;

- ✓ манлайлах, хамтач байх;
- ✓ төрийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй шуурхай хүргэх;
- ✓ хүнд суртал, авлига, хээл хахууль, шан харамжаас ангид байх;
- ✓ иргэд, гүйцэтгэгчдийг хүндэлж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагад хүндэтгэлтэй хандах.

## 5.2 Үнэт зүйлс:

✓ БИД БҮТЭЭЛЧ, ИЛ ТОД, ХУУЛЬ ДЭЭДЭЛДЭГ БАЙНА.

Ажилтан бүр хариуцсан ажилдаа бүтээлчээр хандаж, үйл ажиллагаандаа "Ил тод байх" зарчмыг баримтлах, хууль дүрэм болон дэг журмыг сайн засаглалыг нийгмийнхээ хэрэгцээ шаардлагатай уялдуулан асуудлаа хамт олноороо шийдвэрлэдэг байна.

✓ БИД ЁС ЗҮЙТЭЙ, ШУДАРГА, НЭЭЛТТЭЙ БАЙНА.

Төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын ёс зүйн дүрмийг баримтлан, соёлтой, шударга, ил тод нээлттэй байдлыг эрхэмлэдэг байна.

✓ БИД МЭДЛЭГ, ЧАДВАРТАЙ ХАМТ ОЛОН БАЙНА.

Нэгдсэн зохион байгуулалттай, хөрвөх чадвартай мэргэшсэн, чадварлаг хамт олонд түшиглэсэн багийг бүрдүүлж ажилладаг байна. Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэх хангалттай мэдлэгийг эзэмшин, түүнийгээ цаг үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, мэргэшсэн үйлчилгээ, дэмжлэгийг үзүүлдэг хамт олон байна.

✓ БИД ХАМТЫН АЖИЛЛАГААТАЙ БАЙНА

Хэрэглэгч болон харилцагчидтайгаа хүндэтгэлтэй, шударга хандаж, хамтын ажиллагааны суурийг батжуулна.

# ЗУРГАА. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Байгууллагын орчны шинжилгээг боловсруулахдаа байгууллагын дотоод орчны шинжилгээ /SWOT/, байгууллагын гадаад орчны шинжилгээ /PEST/ болон хэлтсүүдийн гадаад, дотоод орчны шинжилгээг хийсэн.

"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ нь Нийслэлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх чухал стратегийн байгууллага бөгөөд туршлага, хүний нөөцийн давуу талтай. Гэвч санхүү, шийдвэр гаргалтын хамаарал, процессын удаашрал нь гол сул тал болж байна. Цаашид гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх томоохон мега төслүүдэд хяналт тавьж хамтын ажиллагааг сайжруулснаар үр ашиг нэмэгдэх боломжтой.

## 6.1. Байгууллагын дотоод орчны шинжилгээ /SWOT/

*Хүснэгт 6.1 – 1. Байгууллагын дотоод орчны шинжилгээ /SWOT/*

| НЭГ. ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛ | |
|---|---|
| **Давуу тал:** | **Сул тал:** |
| ✓ Төсвийн хөрөнгөөр Нийслэлд хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтад захиалагчийн хяналт тавьдаг байгууллага | ✓ Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил нэмэгдэж байгаатай уялдуулан нэг хяналтын инженерт ноогдох ажлын тоо хэмжээ нэмэгддэг |
| ✓ Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх туршлагатай | ✓ Хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт төрийн болон бусад байгууллагуудын үйл ажиллагаанаас хамаарч удааширснаар гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг |
| ✓ Мэргэжлийн захиалагчийн хяналт тавих инженер, эдийн засаг, барилга, санхүүгийн мэргэшсэн боловсон хүчинтэй | ✓ Шууд хөрөнгө оруулалт батлагдсанаас газрын асуудалтай төсөл хөтөлбөрүүд бий болдог |
| ✓ Төсвийн хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгцээ шаарлагад тулгуурлан судалж, төлөвлөдөг | |

| | |
|---|---|
| ✓ Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг богино хугацаанд чанартай хийж гүйцэтгүүлэхийн тулд бүсийн системээр ажиллаж байгаа<br>✓ Гүйцэтгэгч байгууллагуудын гүйцэтгэсэн бүтээн байгуулалтын ажил, үйл ажиллагаанд үндэслэн дараагийн хөрөнгө оруулалтын ажил эрсдэл гарахаас урьдчилан сэргийлдэг<br>✓ Хөрөнгө оруулалтын ажлын мэдээ, мэдээллийг ил тод нээлттэй болгох зорилгоор хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээллийн сан, программ хангамжийг тогтмол ажиллуулдаг. | ✓ Тендер зарлах, үнэлэх, шалгаруулах хугацаа төлөвлөснөөс хоцорсноос хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл хугацаандаа хэрэгжих боломжгүй болдог.<br>✓ Бүтээн байгуулалтын ажил зөвхөн дулааны улиралд хийгддэг.<br>✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлууд нь судалгаа, шинжилгээ, зураг төсөвгүйгээр батлагддаг. |
| **ХОЁР. ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛ** | |
| **Боломж:**<br>✓ Гадаадын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах нийслэлд хийгдэж байгаа зарим нэр төрлийн ажлуудад хяналт тавьж ажиллах<br>✓ Нийслэлийн хүн ам, хотжилт өсөж буйтай холбоотойгоор дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хэрэгцээ нэмэгдсэн<br>✓ Мега төслүүдэд хяналт тавьж ажиллах<br>✓ Дотоодын чадварлаг гүйцэтгэгч байгууллагууд нэмэгдэж байна<br>✓ Барилгын шинэ технологи, инноваци нэвтрэх боломж<br>✓ Ажилчдынхаа нийгмийн хангамжийг сайжруулах<br>✓ Ажилчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх | **Аюул занал /Саад бэрхшээл/:**<br>✓ Байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалж төлөвлөсөн ажлын хугацаа хойшлох<br>✓ Барилгын материалын үнэ өсөх, нийлүүлэлт тасалдах эрсдэл<br>✓ Чадваргүй гүйцэтгэгч компани зөвлөх үйлчилгээ болон, тендерт ялах<br>✓ Байгууллагуудын хоорондын уялдаа холбоо муугаас ажил удааширдаг<br>✓ Салбарын норм, дүрэм, стандартын өөрчлөлт орох<br>✓ Улс төрийн нөлөөлөл, бодлогын залгамж чанар алдагдах |

## 6.2. Байгууллагын Гадаад орчны шинжилгээ /PEST/

*Хүснэгт 6.2 – 1. Гадаад орчны шинжилээ /PEST/*

| Улс төрийн хүчин зүйлс | Эдийн засгийн хүчин зүйлс |
|---|---|
| **Эерэг тал**<br>✓ Улсын Их хурал, Засгийн газрын зүгээс нийслэлд хийгдэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн тогтоол шийдвэрүүдийг гаргасан<br>✓ Улсын Их Хурлын гишүүд, салбарын сайд нарын багцын хөрөнгөөр нийслэлд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний тоо нэмэгдэх хандлагатай байна.<br>**Сөрөг тал**<br>✓ Улс төрийн тогтворгүй байдал бий болох<br>✓ Зарим нэр төрлийн хөрөнгө оруулалтын зориулалт өөрчлөгдөх<br>✓ Салбаруудын харилцан адилгүй хөрөнгө оруулалт<br>✓ Төсвийн хөрөнгийг батлахдаа холбогдох хууль, дүрэм журмыг мөрддөггүй. Улс төрийн болон бусад нөлөөлөл орж байгаа нь төсвийн хөрөнгийг судалгаагүй, үр ашигтүй хөрөнгө оруулалтад зарцуулахад хүргэх | **Эерэг тал**<br>✓ Төсвийн эрх мэдэл орон нутагт шилжсэн<br>✓ Улсын төсвөөр нийслэлд хийгдэх хөрөнгө оруулалтын тоо нэмэгдэх хандлагатай.<br>✓ Бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх дотоодын компаниудын тоо, чанарын өсөлт<br>✓ Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд цаашид нийслэлд хэрэгжүүлэх бүтээн байгуулалтад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хандлагатай.<br>**Сөрөг тал**<br>✓ Инфляцийн өсөлт<br>✓ Барилгын материал, шатахуун гэх мэт бараа материалын үнийн өсөлт<br>✓ Импортын бүтээгдэхүүнээс хараат байдал Төсвийн хязгаарлагдмал байдал |
| **Нийгмийн хүчин зүйлс** | **Технологийн хүчин зүйлс** |

| | |
|---|---|
| **Эерэг тал**<br>✓ Сүүлийн жилүүдэд нийслэлд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажилд өгөх үнэлгээ дээшилсэн<br>✓ Бүтээн байгуулалтын ажилд ажиллах орон тоо, ажлын байр нэмэгдэж байгаа<br>**Сөрөг тал**<br>✓ Бүтээн байгуулалтын ажлын мэдээг албан ёсны сувгаар мэдээлээгүйгээс олон нийт ташаа ойлголт авдаг | **Эерэг тал**<br>✓ Техник, технологийн орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, материалыг бүтээн байгуулалтад нэвтрүүлэх болсон<br>✓ Технологийн орчин үеийн дэвшилтэд тоног төхөөрөмж, материал хэрэглэх нь бүтээн байгуулалтын чанарыг сайжруулсан<br>**Сөрөг тал**<br>✓ Техник технологийн манай улсын цаг агаар, орчин нөхцөлд зохицох чадвар<br>✓ Орчин үеийн техник технологийн үнэ өндөр |

## 6.3. Хэлтсүүдийн гадаад, дотоод орчны шинжилгээ /SWOT/

*Хүснэгт 6.3 – 1. Хэлтсүүдийн гадаад, дотоод орчны шинжилгээ*

| Хэлтсүүд | Давуу тал | Сул тал | Боломж | Тулгамдаж буй асуудал |
|---|---|---|---|---|
| Төлөвлөлт судалгааны хэлтэс | -Хөрөнгө оруулалтын ажлын сүүлийн 10 жилийн нэгдсэн мэдээллийн сантай болсон<br>-Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагын судалгааг салбар бүрээр хийх чадвартай<br>-Хөрөнгө оруулалтын судалгааг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах чадвар, туршлагатай.<br>-Дүүрэг, хороодтой байнгын хамтран ажилладаг.<br>-Нийслэлд сонгогдсон УИХ-ын гишүүн, НИТХ-ын төлөөлөгчдөд тогтмол мэдээлэл хүргүүлж хамтран ажилладаг. | -Нийслэл болон холбогдох байгууллагууд хөрөнгө оруулалтын судалгаа, төлөвлөлтийг анхаардаггүй | -Залуу туршлагатай боловсон хүчинтэй.<br>-Нийслэлд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, судалгааны ажлуудыг хийх бүрэн боломжтой. | -Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, судалгааг үнэлэгдэхүйц болгох. |
| Зураг төслийн хяналтын хэлтэс | -Улс, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний зураг төсөлд хяналт тавьснаар тухай төслийг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх боломжийг бий болгодог | -Мэргэжил арга зүйн зөвлөгөөг хэрэгжүүлж хяналт тавихад чиглэл бүрийн инженер дутмаг байдаг | -Нийслэлд хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсвийг хийж гүйцэтгэх | -Чиглэлийн инженер дутмаг, цахилгааны инженер, ус хангамж, ариутгах татуургын инженер, мэргэшсэн төсөвчин нэмэх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Барилга захиалагчийн хяналтын хэлтэс | -Улс, Нийслэлийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн техник хяналтын чиг үүргийг хэрэгжүүлснээр барилгын ажлыг зохих зөвшөөрөл, зураг төсөл, стандарт, техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгүүлж, хөрөнгө оруулалтын өгөөжийг дээшлүүлж, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай зарцуулах нөхцөлийг бүрдүүлдэг. | -Барилга угсралтын үйл ажиллагаа явуулах технологийн хугацаа богино, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төсөвт баталдаг, тендер шалгаруулалт оройтдог, чадваргүй гүйцэтгэгч сонгон шалгаруулдаг зэргээс шалтгаалж тухайн жилд батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан гүйцэтгэлийг хангуулахад хүндрэл үүсдэг. | -Монгол улс, Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй эдийн засгийн байдал, түүнийг дагасан хөрөнгө оруулалтын зардал<br>-Нийслэлд амьдарч буй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангах хөрөнгө оруулалтыг гадаадын зээл тусламжаар бий болгож буй байдал | -Захиалагчийн техник хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх Барилгын тухай хууль, Захиалагчийн дүрмийн шаардлагыг хангах ажлын дадлага, туршлага бүхий бүрэлдэхүүнийг бий болгож, инженерүүдийг чадавхижуулах.<br>-Дүүрэг бүрт хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээ, төсөл, арга хэмжээний тооноос хамаарч инженерүүдийн ачаалал харилцан адилгүй байгааг тэнцвэржүүлэх |
| Захиргааны хэлтэс | -Ажлын туршлага, багаар ажиллах чадвартай<br>-Байгууллагын дотоод зохион байгуулалт үйл ажиллагааны үр дүн тус хэлтсээр дамжиган илэрхийлэгдэж байдаг | -Ажиллах орчин үеийн техник хэрэгслээр бүрэн хангагдаагүй | -Ажилчдынхаа нийгмийн хангамжийг сайжруулах үйл ажиллагаа зохион байгуулах<br>-Мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт | -Хэлтсүүд мэдээ тайлан болон хугацаатай үүрэг даалгаврын биелэлтүүдийг хугацаанд нь өгдөггүй, чирэгдүүлдэг<br>-Олон нийтийн арга хэмжээнд оролцох оролцоо идэвхи санаачилга сул |
| Санхүү, аж ахуйн хэлтэс | -Санхүүгийн хувьд бие даасан орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар<br>-Сангийн сайдын журмын дагуу улс нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ажлуудын санхүүжилтийг бусад эргэлтийн хөрөнгөндөө бүртгэснээр хөрөнгө оруулалтын ажлын бүртгэл сайжирсан.<br>-Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудын батлагдсан | -Улс, Нийслэлийн батлагдсан төсвийн хөрөнгөөс манай газрын орлого шууд хамаардаг.<br>-Эргэлтийн хөрөнгөндөө бүртгэснээр хөрөнгө оруулалтын ажлын бүртгэл сайжирсан хэдий ч манай газрын нийт хөрөнгө бодит бусаар өсөж тайлагнагддаг.<br>-Хөрөнгө оруулалтын ажлын | -Бусад эх үүсвэрээр орлого нэмэгдүүлэх/Хувийн хэвшлийн болон гадаадын зээл тусламж/<br>-Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газартай манай газрын хяналтын инженерүүд, санхүүгийн ажилтнуудын ажлын уялдаа холбоог сайжруулах.<br>-Цаашид цахим тендер шиг онлайнд шилжих боломж байгаа. Ковид-19 цар тахал болон | -2021 онд Ковид 19 цар тахлын улмаас улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлууд багассанаас орлого буурч зардлаа нөхөх боломжгүй болсон<br>-Дууссан хөрөнгө оруулалтын ажлуудыг бүртгэлээс хасахад зарим ажлын ашиглагч тодорхой бус байхаас гадна ашиглагч байгууллагуудын хөрөнгийг дансандаа бүртгэх шийдвэр удаашралтай гардаг.<br>-Мөн дууссан зураг төсөв, зөвлөх үйлчилгээний |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | гүйцэтгэлийн санхүүжилтийн явцыг цахимаар хянах боломжтой Нягтлан бодогч, мэргэжилтнүүд нэгдсэн санхүүгийн "Винница" программ дээр ажилладаг. -Мэргэжлийн залуу боловсон хүчинтэй. | гүйцэтгэлийг цахимаар хянах боломжгүй -Цахим санхүүгийн программ байхгүй. -Мэргэшсэн нягтлан бодогч цөөхөн. | бусад шаардлагатай үед цахимаар ажиллах боломжтой. -НЗДТГ-ын СТСХэлтсээс нэгдсэн сургалт зохион байгуулах талаар санал хүргүүлэх боломжтой. | ажлуудыг хэрхэн бүртгэлээс хасах нь тодорхойгүй байна. -Төсвийн орлогын тасалдлаас болж хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт удаашралтай байгаа нь олон хүндрэлийг бий болгож байна. -Ажлын байрны жигд ажиллагаа алдагдах тул удаан хугацаагаар сургалтад цаг гаргаж явуулж чаддаггүй. |
| Хууль дотоод хяналтын хэлтэс | Барилгын ажлыг зохих зөвшөөрөл, зураг төсөл, стандарт, техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгүүлэхэд хяналт тавих үйл ажиллагаа болон барилга байгууламжийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу бүрдүүлэхэд үүссэн алдааг эрт илрүүлэх | -БУА-ын материал тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг оновчтой зөв зохион байгуулахад оролцох оролцоо дутмаг - Захиалагч зохиогчийн уялдаа холбоо сайжруулахад оролцоо дутмаг, оролцоо байхгүй -Гэрээт ажлын үр дүнг 100% хүлээн авч гэрээ дуусгавар болгох, дүгнэх байдал бүрэн хангалттай биш -Барилга угсралтын ажилд авто замын ажил орсон тохиолдолд авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхой бус байна. | Захиалагч барилгын үйл ажиллагаанд холбогдох норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих замаар захиалагч, гүйцэтгэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаална | Барилгын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, чанаргүй, дутуу гүйцэтгэсэн тохиолдолд захиалагч барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахгүй байхаар заасан ч хэрэгждэггүй. |
| Мэдээллийн технологийн хэлтэс | -Боловсон хүчин хангалттай -Тоног төхөөрөмж бүрэн | | -Техник тоног төхөөрөмж хангалттай | -Дотоод бүртгэл мэдээллийн системийг шинэчилж НХОГ-аар хяналт тавьж байгаа ажлуудын явц болон санхүүжилтийн явц |

| | |
|---|---|
| | мэдээллийг гар утас болон вэб хэлбэрээр ашиглах боломжийг бүрдүүлэх, программ хангамж нэвтрүүлэхэд санхүүгийн асуудалтай байна. |

## ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Стратеги төлөвлөгөөг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2024-2028 оны Стратеги төлөвлөгөөний засаглалын шинэчлэлийн зорилго, хүлээгдэж буй үр дүн, тэргүүлэх чиглэлийн хүрээнд нийцүүлэн "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын 2024-2028 оны Стратеги төлөвлөгөөний зорилгыг боловсруулж байна. Байгууллагын стратеги төлөвлөгөө **7 зорилго, 22 зорилтын** хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Стратегийн зорилго нь байгууллагын соёл, манлайлал, үнэ цэнэтэй бүтээн байгуулалт, гүйцэтгэл, оролцогч талуудын сэтгэл ханамж болон өөрчлөлтийн удирдлагыг хамарсан байгууллагын үндсэн чиглэлүүд болно.

### Стратегийн зорилго, зорилгыг хэрэгжүүлэх зорилтууд:

*Хүснэгт 7 – 1. Стратегийн зорилго, зорилт*

| Д/д | СТРАТЕГИЙН ЗОРИЛГО | СТРАТЕГИЙН ЗОРИЛТ |
|---|---|---|
| 1. | **Зорилго 1:** Эрх шилжсэн бүтээн байгуулалтын ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх | **Зорилт 1.1:** Бүтээн байгуулалтын ажлуудын захиалагчийн техник хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх, техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн баримт бичгийг хянах<br>**Зорилт 1.2:** Хяналтын инженерийн ачааллыг тэнцвэржүүлэх |
| 2. | **Зорилго 2:** Эрх шилжсэн зураг төсвийн ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх | **Зорилт 2.1:** Зураг төсвийн ажлуудын захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх, гүйцэтгэл, санхүүгийн баримт бичгийг хянах<br>**Зорилт 2.2:** Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй төсөл арга хэмжээний зураг төсөлд захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх<br>**Зорилт 2.3:** Худалдан авах ажиллагааны бэлтгэл хангах ажлын хүрээнд холбогдох бичиг баримтыг боловсруулж батлуулах, хүргүүлэх |
| 3. | **Зорилго 3:** Санхүүгийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлж, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллах | **Зорилт 3.1:** Хөрөнгө оруулалтын ажлын санхүүгийн баримт бичиг хянах, батлуулах, санхүүжүүлэх, хөрөнгийг бүртгэх<br>**Зорилт 3.2:** Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтыг хангаж ажиллах<br>**Зорилт 3.3:** Санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах |
| 4. | **Зорилго 4:** Хөрөнгө оруулалтыг суурь судалгаанд үндэслэн оновчтой төлөвлөх, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх | **Зорилт 4.1:** Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл бүртгэх, тайлагнах, Бодлогын баримт бичигт тусгагдсан хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хангах<br>**Зорилт 4.2:** Хөрөнгө оруулалтыг хэрэгцээ шаардлагын судалгаанд үндэслэн төлөвлөж, төсөл хөтөлбөрийг боловсруулах, үр өгөөжийн дүн шинжилгээ хийх<br>**Зорилт 4.3:** Бодлогын баримт бичигт тусгагдсан хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хангах |
| 5. | **Зорилго 5:** Дотоод хяналтыг сайжруулан хууль, эрх зүй, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллах | **Зорилт 5.1:** Газрын үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль, эрх зүй, бодлого, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажиллах<br>**Зорилт 5.2:** Хөрөнгө оруулалтын ажлын гэрээ, зохиогчийн хяналтын болон бусад иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулах гэрээний хууль зүйн үндэслэл, бүрдлийг хянах, гэрээ байгуулах |

| | | |
|---|---|---|
| | | **Зорилт 5.3:** Барилга угсралт, их засвар, зураг төсвийн ажлын техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл хянах |
| 6. | **Зорилго 6:** Мэдээллийн технологи, ил тод байдлыг сайжруулж, олон нийттэй үр дүнтэй харилцах | **Зорилт 6.1:** Олон нийт, хэвлэл мэдээллийн харилцаа, мэдээллийн ил тод байдлыг хангах<br>**Зорилт 6.2:** Мэдээллийн системийн аюулгүй, тасралтгүй ажиллагааг хангах замаар байгууллагын цахим системийг хөгжүүлэх |
| 7. | **Зорилго 7:** Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх | **Зорилт 7.1:** Зорилго, алсын хараа, стратегийг сайжруулах<br>**Зорилт 7.2:** Байгууллагын соёл ба манлайллыг хөгжүүлэх<br>**Зорилт 7.3:** Оролцогч талуудын оролцоо хангах<br>**Зорилт 7.4:** Тогтвортой үнэ цэнийг бий болгох<br>**Зорилт 7.5:** Гүйцэтгэл ба өөрчлөлтийн удирдлагыг сайжруулах<br>**Зорилт 7.6:** Оролцогч талуудын сэтгэл ханамж, ойлголтыг дээшлүүлэх<br>**Зорилт 7.7:** Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх |

## НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ

### 8.1. Стратегийн зорилго, бүтцийн уялдаа

Байгууллагын стратегийн зорилго, зорилт ба хариуцах байгууллага, нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог дараах байдлаар хангаж ажиллана.

*Хүснэгт 8.1 – 1. Стратегийн зорилго, бүтцийн уялдаа*

| Д/д | Үндсэн чиг үүрэг | Стратегийн зорилго | Стратегийн зорилт | Хэрэгжүүлэгч байгууллага, нэгж | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Үндсэн хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч |
| 1 | ҮЧҮ-1, 5, 7 | **Зорилго 1:** Эрх шилжсэн бүтээн байгуулалтын ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх | **Зорилт 1.1:** Бүтээн байгуулалтын ажлуудын захиалагчийн техник хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх, техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн баримт бичгийг хянах<br>**Зорилт 1.2:** Хяналтын инженерийн ачааллыг тэнцвэржүүлэх | Барилга захиалагчийн хяналтын хэлтэс | Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харьяа газар агентлагууд, Дүүргүүд, Гүйцэтгэгч компаниуд |
| 2 | ҮЧҮ-3 | **Зорилго 2:** Эрх шилжсэн зураг төсвийн ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх | **Зорилт 2.1:** Зураг төсвийн ажлуудын захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх, гүйцэтгэл, санхүүгийн баримт бичгийг хянах<br>**Зорилт 2.2:** Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй төсөл арга хэмжээний зураг төсөлд захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх<br>**Зорилт 2.3:** Худалдан авах ажиллагааны бэлтгэл хангах ажлын хүрээнд холбогдох бичиг баримтыг боловсруулж батлуулах, хүргүүлэх | Зураг төслийн хяналтын хэлтэс | Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харьяа газар агентлагууд, Дүүргүүд, Гүйцэтгэгч компаниуд |
| 3 | ҮЧҮ-4 | **Зорилго 3:** Санхүүгийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлж, санхүүгийн ил | **Зорилт 3.1:** Хөрөнгө оруулалтын ажлын санхүүгийн баримт бичиг хянах, батлуулах, санхүүжүүлэх, хөрөнгийг бүртгэх **Зорилт 3.2:** Эдийн | Санхүү, аж ахуйн хэлтэс | Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харьяа газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тод байдлыг хангаж ажиллах | засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтыг хангаж ажиллах<br>**Зорилт 3.3:** Санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах | | агентлагууд, Дүүргүүд, Гүйцэтгэгч компаниуд |
| 4 | ҮЧҮ-2, 6 | **Зорилго 4:** Хөрөнгө оруулалтыг суурь судалгаанд үндэслэн оновчтой төлөвлөх, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх | **Зорилт 4.1:** Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл бүртгэх, тайлагнах, Бодлогын баримт бичигт тусгагдсан хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хангах<br>**Зорилт 4.2:** Хөрөнгө оруулалтыг хэрэгцээ шаардлагын судалгаанд үндэслэн төлөвлөж, төсөл хөтөлбөрийг боловсруулах, үр өгөөжийн дүн шинжилгээ хийх<br>**Зорилт 4.3:** Бодлогын баримт бичигт тусгагдсан хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хангах | Төлөвлөлт судалгааны хэлтэс | Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харъяа газар агентлагууд, Дүүргүүд |
| 5 | ҮЧҮ-8 | **Зорилго 5:** Дотоод хяналтыг сайжруулан хууль, эрх зүй, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллах | **Зорилт 5.1:** Газрын үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль, эрх зүй, бодлого, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажиллах<br>**Зорилт 5.2:** Хөрөнгө оруулалтын ажлын гэрээ, зохиогчийн хяналтын болон бусад иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулах гэрээний хууль зүйн үндэслэл, бүрдлийг хянах, гэрээ байгуулах<br>**Зорилт 5.3:** Барилга угсралт, их засвар, зураг төсвийн ажлын техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл хянах | Хууль, дотоод хяналтын хэлтэс | Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харъяа газар агентлагууд, Дүүргүүд, Гүйцэтгэгч компаниуд |
| 6 | ҮЧҮ-8 | **Зорилго 6:** Мэдээллийн технологи, ил тод байдлыг сайжруулж, олон нийттэй үр дүнтэй харилцах | **Зорилт 6.1:** Олон нийт, хэвлэл мэдээллийн харилцаа, мэдээллийн ил тод байдлыг хангах<br>**Зорилт 6.2:** Мэдээллийн системийн аюулгүй, тасралтгүй ажиллагааг хангах замаар байгууллагын цахим системийг хөгжүүлэх | Мэдээллийн технологийн хэлтэс | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага |
| 7 | ҮЧҮ-8 | **Зорилго 7:** Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх | **Зорилт 7.1:** Зорилго, алсын хараа, стратегийг сайжруулах<br>**Зорилт 7.2:** Байгууллагын соёл ба манлайллыг хөгжүүлэх<br>**Зорилт 7.3:** Оролцогч талуудын оролцоо хангах<br>**Зорилт 7.4:** Тогтвортой үнэ цэнийг бий болгох | Захиргааны хэлтэс | Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харъяа газар агентлагууд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | **Зорилт 7.5:** Гүйцэтгэл ба өөрчлөлтийн удирдлагыг сайжруулах<br>**Зорилт 7.6:** Оролцогч талуудын сэтгэл ханамж, ойлголтыг дээшлүүлэх<br>**Зорилт 7.7:** Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх | | |

## 8.2. Стратегийн зорилго, бодлогын баримт бичгийн уялдаа

*Хүснэгт 8.2 – 1. Стратегийн зорилго, бодлогын баримт бичгийн уялдаа*

| Стратегийн зорилго | МУЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр | НЗД-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл |
|---|---|---|---|
| 1. Эрх шилжсэн бүтээн байгуулалтын ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх | 1.1.2.1. заалт<br>1.1.2.2. заалт<br>1.1.3.6. заалт<br>1.2.1.3. заалт<br>4.2.2.5. заалт | 1.3.3. заалт<br>1.3.5. заалт<br>1.3.23. заалт<br>2.1. заалт<br>2.2. заалт<br>3.3.1. заалт<br>4.5.1 заалт | 9. заалт |
| 2. Эрх шилжсэн зураг төсвийн ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх | 3.4.3.2. заалт<br>4.2.2.5. заалт | 1.1.1. заалт<br>1.2.16. заалт | 9. заалт |
| 3. Санхүүгийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлж, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллах | 2.1.3.7. заалт | 3.1. заалт<br>3.2. заалт | 4.1.3. заалт |
| 4. Хөрөнгө оруулалтыг суурь судалгаанд үндэслэн оновчтой төлөвлөх, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх | 3.2.2.14. заалт<br>4.2.2.5. заалт | 3.1. заалт<br>5.1.2. заалт | 4.1.3. заалт |
| 5. Дотоод хяналтыг сайжруулан хууль, эрх зүй, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллах | 4.2.3.11. заалт<br>4.2.3.12. заалт | 5.1.4. заалт<br>5.1.5. заалт | 5.1. заалт |
| 6. Мэдээллийн технологи, ил тод байдлыг сайжруулж, олон нийттэй үр дүнтэй харилцах | 4.1.2.2. заалт | 5.2.4. заалт<br>5.2.6. заалт | 5.2. заалт |
| 7. Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх | 4.2.3.1. заалт<br>4.2.3.5. заалт<br>4.2.3.6. заалт | 5.1.10. заалт<br>5.1.11. заалт<br>5.1.15. заалт<br>5.1.16. заалт | 5.3. заалт |

## 8.3. Стратегийн зураглал

# "НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛ

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Алсын хараа** | Хүрээлэн буй орчинд ээлтэй чанарыг эрхэмлэсэн бүтээн байгуулалтыг цогцлооно. | | | | | | |
| **Эрхэм зорилго** | Олон улсын түвшинд нийцсэн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлнэ. | | | | | | |
| **Үнэт зүйл** | ✓ Бид бүтээлч, ил тод, хууль дээдэлдэг байна.<br>✓ Бид ёс зүйтэй, шударга, нээлттэй байна.<br>✓ Бид мэдлэг, чадвартай хамт олон байна.<br>✓ Бид хамтын ажиллагаатай байна. | | | | | | |
| **Стратегийн зорилго** | 1. Эрх цөлөөсөн бүтээн байгуулалтын ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх | 2. Эрх цөлөөсөн зураг төсвийн ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх | 3. Санхүүгийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлж, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллах | 4. Хөрөнгө оруулалтыг суурь судалгаанд үндэслэн оновчтой төлөвлөх, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх | 5. Дотоод хяналтыг сайжруулан хууль, эрх зүй, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллах | 6. Мэдээллийн технологи, ил тод байдлыг сайжруулж, олон нийттэй үр дүнтэй харилцах | Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх |
| **Стратегийн зорилт** | 1.1.Бүтээн байгуулалтын ажлуудын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх, техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн баримт бичгийг хянах шилжүүлэх<br>1.2. Хяналтын инженерийн ачааллыг тэнцвэржүүлэх | 2.1. Зураг төсвийн ажлуудын захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх, гүйцэтгэл, санхүүгийн баримт бичгийг хянах<br>2.2. Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй төсөл арга хэмжээний зураг төсөлд захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх<br>2.3. Худалдан авах ажиллагааны бэлтгэл хангах ажлын хүрээнд холбогдох бичиг баримтыг боловсруулж батлуулах, хүргүүлэх | 3.1. Хөрөнгө оруулалтын ажлын санхүүгийн баримт бичиг хянах, батлуулах, санхүүжүүлэх, хөрөнгийг бүртгэх<br>3.2. Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтыг хангаж ажиллах<br>3.3. Санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах | 4.1. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл бүртгэх, тайлагнах, Бодлогын баримт бичигт тусгагдсан хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хангах<br>4.2. Хөрөнгө оруулалтыг хэрэгцээ шаардлагын судалгаанд үндэслэн төлөвлөх, төсөл хөтөлбөрийг боловсруулах, үр өгөөжийн дүн шинжилгээ хийх<br>4.3. Бодлогын баримт бичигт тусгагдсан хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хангах | 5.1. Газрын үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль, эрх зүй, бодлого, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажиллах<br>5.2. Хөрөнгө оруулалтын ажлын гэрээ, зохиогчийн хяналтын болон бусад иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулах гэрээний хууль зүйн үндэслэл, бүрдлийг хянах, гэрээ байгуулах<br>5.3. Барилга угсралт, их засвар, зураг төсвийн ажлын техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл хянах | 6.1.Олон нийт, хэвлэл мэдээллийн харилцаа, мэдээллийн ил тод байдлыг хангах<br>6.2.Мэдээллийн системийн аюулгүй, тасралтгүй ажиллагааг хангах замаар байгууллагын цахим системийг хөгжүүлэх | 7.1. Зорилго, алсын хараа, стратегийг сайжруулах<br>7.2. Байгууллагын соёл ба манлайллыг хөгжүүлэх<br>7.3. Оролцогч талуудын оролцоо хангах<br>7.4. Тогтвортой үнэ цэнийг бий болгох<br>7.5. Гүйцэтгэл ба өөрчлөлтийн удирдлагыг сайжруулах<br>7.6. Оролцогч талуудын сэтгэл ханамж, ойлголтыг дээшлүүлэх<br>7.7. Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх |
| **Стратеги** | * Бүтээн байгуулалтын ажлуудын захиалагчийн техник хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх, техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн баримт бичгийг хянах<br>*Томоохон мега төсөл, хөтөлбөрүүдэд хамтарч ажиллах | *Зөвлөх үйлчилгээ, түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй зураг төсөв боловсруулах ажлуудад захиалагчийн техник хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх | *Үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагааг хэвийн үр ашигтай явуулах, санхүүгийн сахилга бат, тайлагналын ил тод байдлыг хангах замаар төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх | *Хөрөнгө оруулалтын судалгааг тогтмол хийж үр дүнгийн саналаа холбогдох газруудад хүргүүлэх, хөрөнгө оруулалтын ажлуудын мэдээ, мэдээллийг гаргах, тайлагнах | *Үйлдвэрийн газрын дотоод хяналтыг сайжруулах хууль, эрх зүй, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллах | *Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэд, олон нийтэд мэдээ мэдээллийг ил тод хүргэх | *Үйлдвэрийн газрын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэх, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах |
| **Хариуцах нэгж** | Барилга захиалагчийн хяналтын хэлтэс | Зураг төслийн хяналтын хэлтэс | Санхүү, аж ахуйн хэлтэс | Төлөвлөлт судалгааны хэлтэс | Хууль, дотоод хяналтын хэлтэс | Мэдээллийн технологийн хэлтэс | Захиргааны хэлтэс, Хууль, дотоод хяналтын хэлтэс, Санхүү, аж ахуйн хэлтэс, Барилга захиалагчийн хяналтын хэлтэс, Төлөвлөлт судалгааны хэлтэс |
| | Салбарын яамдууд, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, хамтран ажилладаг иргэд, аж ахуйн нэгжүүд | | | | | | |
| **Мандат** | - Хүрээлэн буй орчинд ээлтэй бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэх<br>- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх<br>- Хууль, эрх зүй, дүрэм, журам, стандартыг мөрдөж, аюулгүй байдлыг хангах<br>- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, төсөв санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах | | | | | | |

## ЕС. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгууллагын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлснээр нөөцийн ашиглалтаа сайжруулж, илүү хариуцлагатай, ил тод, олон талын оролцоонд тулгуурласан байдлаар тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх боломжтой болно гэж үзсэн.

*Хүснэгт 9 – 1. "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын 2024-2028 оны Стратеги төлөвлөгөө*

| Бодлогын баримт бичигт тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Стратеги (арга зам) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2021-2024 он) | Зорилтод түвшин (2024-2028 он) | Санхүүжил-тийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|
| **Ерөнхий чиг үүрэг: Захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх, чанар, үр дүнг дээшлүүлэх**<br>**Үндсэн чиг үүрэг: Улс, Нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн болон бусад хөрөнгө оруулалтаар хэрэгжиж төсөл арга хэмжээнд гэрээний үндсэн дээр гүйцэтгэлийн хяналт тавих** | | | | | |
| 1.1. Бүтээн байгуулалтын ажлуудын захиалагчийн техник хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх, техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн баримт бичгийг хянах | Арга хэмжээ 1.1.1.<br>Тухайн жилийн төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээнээс эрх шилжүүлэх замаар барилга угсралт, их засварын ажилд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх | Хяналт тавих бүтээн байгуулалтын ажлын хэрэгжилтийн хувь | 100% | 100% | - |
| 1.2. Хяналтын инженерийн ачааллыг тэнцвэржүүлэх | Арга хэмжээ 1.2.1.<br>Инженер техникийн ажилчдын ачааллыг тэнцвэржүүлэх бүсийн системд зохион байгуулалт хийх | Тухай бүр | - | - | - |
| **Үндсэн чиг үүрэг: Зураг төслийг хянах, түүний хэрэгжилтийн ажлыг зохион байгуулах, зураг төсвийн ажилд гэрээний үндсэн дээр хяналт тавих** | | | | | |
| 2.1. Зураг төсвийн ажлуудын захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх, гүйцэтгэл, санхүүгийн баримт бичгийг хянах | Арга хэмжээ 2.1.1.<br>Зураг төсвийн ажилд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх | Хяналт тавих зураг төсвийн ажлын хэрэгжилтийн хувь | 100% | 100% | - |
| 2.2. Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй төсөл арга хэмжээний зураг төсөлд захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх | Арга хэмжээ 2.2.1.<br>Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй төсөл арга хэмжээний зураг төсөлд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх | Хяналт тавих зураг төсвийн ажлын хэрэгжилтийн хувь | 100% | 100% | - |
| 2.3. Худалдан авах ажиллагааны бэлтгэл хангах ажлын хүрээнд холбогдох бичиг баримтыг боловсруулж батлуулах, хүргүүлэх | Арга хэмжээ 2.3.1.<br>Нийслэлийн Засаг даргаас эрх шилжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын худалдан авах ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж ажиллах | Эрх шилжсэн ажлуудын баримт бичиг боловсруулалтын хэрэгжилтийн хувь | 100% | 100% | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Үндсэн чиг үүрэг: Захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулах, төсөл арга хэмжээний техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн бичиг баримтын бүрдлийг хянаж, захиалагчид хүргүүлэн батлуулах** | | | | | |
| 3.1. Хөрөнгө оруулалтын ажлын санхүүгийн баримт бичиг хянах, батлуулах, санхүүжүүлэх, хөрөнгийг бүртгэх | Арга хэмжээ 3.1.1. Хөрөнгө оруулалтын ажлын санхүүгийн баримт бичиг хянах, батлуулах, санхүүжүүлэх | Санхүүгийн баримт бичиг хянах, батлуулах, санхүүжүүлэх ажлын хэрэгжилтийн хувь | 100% | 100% | - |
| | Арга хэмжээ 3.1.2. Хөрөнгө оруулалтын ажлыг хууль, эрх зүйн дагуу хөрөнгийн бүртгэл хийх | Хөрөнгийн бүртгэлийн хэрэгжилтийн хувь | 100% | 100% | - |
| 3.2. Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтыг хангаж ажиллах | Арга хэмжээ 3.2.1. Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | - |
| | Арга хэмжээ 3.2.2. Газрын санхүүгийн үйл ажиллагааг хэвийн үр ашигтай явуулж, мөнгөний урсгалыг зөв төлөвлөж, эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт зарцуулалтад хяналт тавьж, контракт гэрээний биелэлтийг хангаж ажиллах | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | - |
